

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ДҮРЭМ	DC R-02
	Батлагдсан огноо: 2025-12-25	Хувилбар № 01

Агуулга

1.0 Зорилго	2
2.0 Хамрах хүрээ.....	2
3.0 Норматив, эш татсан баримт бичиг	2
4.0 Нэр томъёо, тодорхойлолт	2
5.0 Баталгаажуулалтын шаардлага.....	3
5.1 Баталгаажуулалт олгох шалгуур	3
5.2 Баталгаажуулалтын үйл явцын шаардлага.....	4
5.2.1 Баталгаажуулалтын гэрээ.....	4
5.2.2 1-р шатны аудит буюу баримтжуулсан мэдээллийн үзлэг-дүн шинжилгээ	4
5.2.3 2-р шатны аудит	4
5.2.4 Үл тохирлын тайлан	4
5.2.5 Баталгаажуулалтыг олгох шийдвэр гаргах.....	5
5.2.6 Баталгаажуулалтын гэрчилгээний хүчинтэй байдал.....	5
5.2.7 Магадлан хяналтын аудит.....	5
5.2.8 Давтан баталгаажуулалтын аудит	6
5.2.9 Тусгай аудит	6
5.3 Баталгаажуулалтын өөрчлөлтийг мэдэгдэх.....	6
5.3.1 ДС ББ-ын баталгаажуулалтын шаардлагын өөрчлөлтийг мэдэгдэх	6
5.3.2 Үйлчлүүлэгч нь өөрчлөлтөө мэдэгдэх	6
5.4 Баталгаажуулалтын хүчин төгөлдөр байдлыг хадгалах	7
5.5 Баталгаажуулалтыг түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон хамрах хүрээг багасгах ...	7
5.5.1. Баталгаажуулалтыг түдгэлзүүлэх.....	7
5.5.2 Баталгаажуулалтыг цуцлах.....	8
5.5.3 Баталгаажуулалтын хүрээг багасгах.....	8
5.6 Баталгаажуулалтын тэмдэг/лого ашиглах	8
5.7 Нийтэд нээлттэй мэдээлэл	9
5.8 Хүсэлт гаргагч/баталгаажуулагдсан байгууллагын үүрэг	9
5.9 ДС Баталгаажуулалтын байгууллагын үүрэг.....	10
6. Баталгаажуулалтын ерөнхий нөхцөл.....	11

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ДҮРЭМ	DC R-02
	Батлагдсан огноо: 2025-12-25	Хувилбар № 01

1.0 Зорилго

ДС ББ-ын баталгаажуулалтын үйл ажиллагааг MNS ISO/IEC 17021-1 стандартын дагуу оролцогч болон сонирхогч талуудад ил тод, шударга, хяналттай хэрэгжүүлэх, мэдээллээр хангах зорилготой.

2.0 Хамрах хүрээ

Энэ дүрэм нь ДС ББ-аас менежментийн тогтолцооны баталгаажуулалтыг олгох, татгалзах, хадгалах, давтан баталгаажуулах, баталгаажуулалтын хүрээг өргөтгөх эсвэл багасгах, шинэчлэх, түдгэлзүүлэх, цуцлахад баримтлах ерөнхий дэг болон ДС ББ-ын болон үйлчлүүлэгчийн хүлээх үүрэг хариуцлагыг хамарсан болно.

3.0 Норматив, эш татсан баримт бичиг

MNS ISO/IEC 17021-1:2020, Тохирлын үнэлгээ. Менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалтыг гүйцэтгэх байгууллагад тавих шаардлага. 1-р хэсэг: Шаардлага

4.0 Нэр томъёо, тодорхойлолт

MNS ISO/IEC 17021-1:2020 стандартад заасан нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэнэ

4.1 үйлчлүүлэгч

баталгаажуулалтын зорилгоор менежментийн тогтолцоо нь аудитад хамрагдах байгууллага

4.2 баталгаажуулагдсан үйлчлүүлэгч

ДС ББ-аар менежментийн тогтолцоо нь баталгаажуулагдсан байгууллага

4.3 шударга байдал

бодитой, үнэнч байдлын илэрхийлэл

ТАЙЛБАР 1: Бодитой, үнэнч байдал гэдэг нь ашиг сонирхлын зөрчилгүй байх эсвэл уг зөрчлийг баталгаажуулалтын байгууллагын холбогдох үйл ажиллагаанд хохирол үчруулахгүй шийдвэрлэхийг хэлнэ.

ТАЙЛБАР 2: Шударга байдлыг тайлбарлах бусад нийтлэг нэр томъёонд “бие даасан байх”, “ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх”, “нэг талыг баримтлахгүй байх”, “хохиролгүй байх”, “төвийг сахих”, “үнэнч байх”, “нээлттэй байх”, “адил тэгш хандах”, “зай барих”, “тэнцвэрийг хадгалах” зэрэг багтана.

4.4 үл тохирол

шаардлага үл биелэх байдал

4.5 том үл тохирол

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ДҮРЭМ	DC R-02
	Батлагдсан огноо: 2025-12-25	Хувилбар № 01

Зорьсон үр дүнд хүрэх менежментийн тогтолцооны чадавхад нөлөөлөх үл тохирол

ТАЙЛБАР 1: Үл тохирлыг дараах нөхцөлд том гэж ангилж болно. Үүнд:

- а) үйл явцын үр дүнтэй хяналт хэрэгжиж байгаа эсэх, бүтээгдэхүүн ба үйлчилгээ тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхэд ноцтой зөрүү байгаа бол;*
- б) нэг ижил шаардлагад хамааралтай олон жижиг үл тохирол эсвэл тогтолцооны доголдлыг харуулж болох асуудал, үүнээс том үл тохирол бий болох;*

4.6 жижиг үл тохирол

Зорьсон үр дүнд хүрэх менежментийн тогтолцооны чадавхад нөлөөлөхгүй үл тохирол.

4.7 1-р шатны Аудит

Менежментийн тогтолцооны баримт бичгийг холбогдох стандарт (ууд) -ын дагуу шалгаж, баталгаажуулалтын хүрээг тогтоох зохих туршлагатай аудитын багийг томилон 2-р шатны аудитын ажилд бэлэн байдлыг үнэлэх урьдчилсан аудит.

4.8 2-р шатны Аудит

ДС ББ-аас томилсон аудитын баг холбогдох стандарт (ууд) -ын нийцлийг үнэлэх аудит. Үйлчлүүлэгчийн үйл явц нь холбогдох стандарт(ууд) ба үйлчлүүлэгчийн менежментийн тогтолцооны баримт бичигт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулна.

5.0 Баталгаажуулалтын шаардлага

5.1 Баталгаажуулалт олгох шалгуур

ДС ББ нь дараах шалгуурыг хангасан тохиолдолд үйлчлүүлэгчид баталгаажуулалтын гэрчилгээг олгоно.

- а) Үйлчлүүлэгч нь баталгаажуулалтын хамрах хүрээндээ нийцсэн, холбогдох менежментийн тогтолцооны стандартын шаардлагыг хангасан баримтжуулсан менежментийн тогтолцоотой байх;
- б) Үйлчлүүлэгч нь бүрдүүлсэн менежментийн тогтолцоондоо жилд дор хаяж нэг удаа дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээ хийсэн байх;
- с) ДС ББ-ын аудитууд нь Үйлчлүүлэгчийн дотоод аудит болон менежментийн дүн шинжилгээг үр дүнтэй явагдсан гэдгийг тогтоосон байх;
- д) ДС ББ-ын баталгаажуулалтын хураамж болон бусад бүх төлбөрийг бүрэн төлсөн байх;
- е) Үйлчлүүлэгч нь бүх гомдол, тэдгээрт авсан арга хэмжээний бүртгэлийг хадгалж, шаардлагатай үед ДС ББ-ын аудиторт шалгуулдаг байх;

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ДҮРЭМ	DC R-02
	Батлагдсан огноо: 2025-12-25	Хувилбар № 01

f) Үйлчлүүлэгч нь 1-р шат болон 2-р шатны аудитад амжилттай хамрагдсан, аудитын баг нь баталгаажуулах санал дүгнэлт өгсөн байх.

5.2 Баталгаажуулалтын үйл явцын шаардлага

5.2.1 Баталгаажуулалтын гэрээ

Үнийн санал хүлээн зөвшөөрөгдсөний дараа ДС ББ болон үйлчлүүлэгчийн хооронд тухайн олон улсын стандартын дагуу менежментийн тогтолцоог баталгаажуулах тухай гэрээг байгуулна.

5.2.2 1-р шатны аудит буюу баримтжуулсан мэдээллийн үзлэг-дүн шинжилгээ

ДС ББ нь үйлчлүүлэгчийн нэвтрүүлсэн менежментийн тогтолцооны холбогдох стандартын шаардлагын дагуу баримтжуулсан мэдээллийн хангалттай байдлыг шалгах, мөн холбогдох дүрэм журмыг оролцуулан үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа, үйл явцын талаарх нэмэлт мэдээллийг цуглуулах, 2-р шатны аудитыг үр дүнтэй төлөвлөхийн тулд 1-р шатны аудит хийнэ. Тухайн үйлчлүүлэгчийн үйлдвэр, ажлын байрыг интернерээр дамжуулан харах, менежментийн тогтолцоонд аудит хийж шаардлагатай мэдээллийг олж авах байдлаар явуулж болно.

ДС ББ нь 1-р шатны аудитад хамрагдсан үйлчлүүлэгчид албан ёсны тайланг хүргүүлнэ.

Үйлчлүүлэгч нь 1-р шатны аудит буюу баримтжуулсан мэдээллийн үзлэг-дүн шинжилгээгээр илэрсэн бүх ажиглалт, зөрчил/асуудлыг бүрэн залруулж, үр дүнтэй шийдвэрлэн хариуг ДС ББ-д мэдэгдэнэ.

5.2.3 2-р шатны аудит

ДС ББ-ын аудитын баг тохиролцсон төлөвлөгөөний дагуу үйлчлүүлэгчийн байршилд очиж явуулна. Үүнд:

- Менежментийн тогтолцооны үр нөлөөтэй хэрэгжилт,
- Холбогдох стандартын шаардлагыг хангаж буй эсэхийг шалгана.

Албан ёсны аудитын тайланг үйлчлүүлэгчид хүргүүлнэ.

5.2.4 Үл тохирлын тайлан

2-р шатны аудитын явцад үл тохирол илэрвэл Үл тохирлын мэдэгдэл/тайлан гаргана.

- Үйлчлүүлэгч нь аудит дууссанаас хойш 15 ажлын хоногийн дотор залруулга болон үл тохирол гарсан шалтгааныг нь арилгах залруулах арга хэмжээний төлөвлөгөөг ДС ББ-д ирүүлнэ.
- Үйлчлүүлэгч нь тогтоосон хугацаанд залруулга болон залруулах арга хэмжээг авч, баримтжуулсан нотлох баримтыг 90 хоногийн дотор ДС ББ-д ирүүлнэ.

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ДҮРЭМ	DC R-02
	Батлагдсан огноо: 2025-12-25	Хувилбар № 01

- ДС ББ нь ирүүлсэн залруулга болон залруулах арга хэмжээний үр нөлөөг үнэлж, хангалттай тохиолдолд үл тохирлыг хаана.

5.2.4.1 Анхдагч баталгаажуулалтын хувьд дараах тохиолдолд аудит цуцлагдана. Үүнд:

- Том үл тохирлын залруулах арга хэмжээг үр дүнтэй авч 90 хоногийн дотор хаалгаагүй
- Жижиг үл тохирлыг 30 хоногт хаалгаагүй.

5.2.4.2 Баталгаажуулагдсан үйлчлүүлэгчдийн хувьд ДС ББ нь дараах нөхцлүүдийн дагуу баталгаажуулалтыг түдгэлзүүлнэ.

- Том үл тохирлын залруулах арга хэмжээг үр дүнтэй авч 90 хоногийн дотор хаалгаагүй.
- Жижиг үл тохирлыг 30 хоногт хаалгаагүй.

5.2.5 Баталгаажуулалтыг олгох шийдвэр гаргах

ДС ББ нь дараах мэдээлэлд үндэслэн үйлчлүүлэгчийн менежментийн тогтолцоог баталгаажуулах шийдвэр гаргана. Үүнд:

(а) ДС ББ нь аудитын тайланд дүн шинжилгээ хийж, аудитын багийн санал, дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн.

(b) Үйлчлүүлэгч нь тогтоосон хугацаанд илэрсэн үл тохирлыг залруулах болон залруулах арга хэмжээг авч, үл тохирлыг хаалгасан.

(с) Том үл тохирлын залруулах болон залруулах арга хэмжээний үр нөлөөг ДС ББ-ын аудиторууд тохиролцсоны дагуу шалгаж, хаасан эсвэл жижиг болгож бууруулсан.

Баталгаажуулалтыг олгох шийдвэрийг гаргах боломжгүй тохиолдолд үйлчлүүлэгчид албан ёсоор заавал мэдэгдэнэ.

5.2.6 Баталгаажуулалтын гэрчилгээний хүчинтэй байдал

ДС ББ-аас олгосон Баталгаажуулалтын гэрчилгээ нь магадлан хяналтын аудитаар үйлчлүүлэгчийн баталгаажуулагдсан менежментийн тогтолцоо нь шаардлагыг тогтмол хангаж байгааг тогтоогдсон тохиолдолд баталгаажуулалтын гэрчилгээ нь баталсан өдрөөс хойш гурван жилийн хугацаанд хүчинтэй байна.

Баталгаажуулалтын гэрчилгээг ДС ББ-ын өмч тул баталгаажуулагдсан үйлчлүүлэгч нь баталгаажуулалтын шаардлагыг хангахгүй тохиолдолд буцаан авах эрхтэй.

5.2.7 Магадлан хяналтын аудит

Үйлчлүүлэгчийн менежментийн тогтолцоо нь баталгаажуулалт олгогдсон стандартын шаардлагыг үргэлжлүүлэн хангаж байгааг нотлохын тулд үйлчлүүлэгчийн байршилд жилд дор хаяж нэг удаа магадлан хяналтын аудитыг явуулна.

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ДҮРЭМ	DC R-02
	Батлагдсан огноо: 2025-12-25	Хувилбар № 01

Анхдагч баталгаажуулалтын хувьд баталгаажуулалтын шийдвэр гаргасан өдрөөс хойш 12 сараас хэтрэхгүй хугацааны дараа магадлан хяналтын аудитыг явуулна.

Үйлчлүүлэгчээс хамаарахгүй гадаад хүчин зүйлсээс болж магадлан хяналтын аудит хийлгэх боломжгүй бол энэ талаар ДС ББ-д мэдэгдэнэ. Тухайлбал: Ажил хаялт, байгалийн гамшиг гэх мэт

5.2.8 Давтан баталгаажуулалтын аудит

Давтан баталгаажуулалтын аудитыг үйлчлүүлэгчийн байршилд явуулах бөгөөд үйлчлүүлэгчийн менежментийн тогтолцооны гүйцэтгэлийг өмнөх баталгаажуулалтын хугацааны туршид үнэлнэ. Магадлан хяналтын аудитын тайланд дүн шинжилгээ хийнэ. Үйлчлүүлэгчийн менежментийн тогтолцоо, үйл ажиллагаа, эсхүл хууль тогтоомжид томоохон өөрчлөлт орсон тохиолдолд давтан баталгаажуулалтын аудитад 1-р шатны аудитыг багтааж болно.

ДС ББ нь үйлчлүүлэгчийн баталгаажуулалтын гэрчилгээний хугацаа дуусахаас наад зах нь 60 хоногийн өмнө давтан баталгаажуулалтын аудитыг явуулна.

5.2.9 Тусгай аудит

ДС ББ нь дараах нөхцөлд тусгай аудит хийнэ. Үүнд:

- (a) Үйлчлүүлэгчийн хүсэлтээр өмнө олгогдсон баталгаажуулалтын хүрээг өргөтгөх. Жич: Хүрээ өргөтгөх асуудлыг магадлан хяналтын аудиттай хамтруулж болно.
- (b) Үйлчлүүлэгчийн талаар гарсан гомдлыг шалгах.
- (c) Баталгаажуулалтыг түдгэлзүүлэх эсвэл том үл тохирлыг залруулсан ажиллагааны үр нөлөөг шалгах.
- (d) ДС ББ-ын баталгаажуулалтын шаардлагад өөрчлөлт оруулсан.

5.3 Баталгаажуулалтын өөрчлөлтийг мэдэгдэх

5.3.1 ДС ББ-ын баталгаажуулалтын шаардлагын өөрчлөлтийг мэдэгдэх

ДС ББ-ын баталгаажуулалтын шаардлагад оруулсан аливаа өөрчлөлтийн талаар үйлчлүүлэгчид урьдчилан мэдэгдэж, дараа нь үйлчлүүлэгчийг энэ шаардлагыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулна. Зарим тохиолдолд тусгай аудит хийх шаардлага үүсч болно.

5.3.2 Үйлчлүүлэгч нь өөрчлөлтөө мэдэгдэх

Үйлчлүүлэгч нь баталгаажуулалтад мөрдсөн стандартын шаардлагыг үргэлжлүүлэн биелүүлэх менежментийн тогтолцооны чадавхид нөлөөлж болзошгүй дараах өөрчлөлтийг ДС ББ-д нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Үүнд:

- (a) Хууль эрх зүйн статус болон өмчлөл өөрчлөгдөх,

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ДҮРЭМ	DC R-02
	Батлагдсан огноо: 2025-12-25	Хувилбар № 01

(b) Байгууллага ба менежмент (жишээ нь, удирдлага, шийдвэр гаргагч болон техникийн ажилтнуудын өөрчлөлт)

(c) Холбоо барих хаяг, байршил

(d) Баталгаажуулалтын хүрээ

(e) Менежментийн тогтолцооны болон үйл явцын томоохон өөрчлөлтүүд.

ДС ББ нь өөрчлөлтийг хянаж, холбогдох стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж нотлох талаар үйлчлүүлэгчтэй хэлэлцэн, цаашид авах арга хэмжээг тодорхойлно.

5.4 Баталгаажуулалтын хүчин төгөлдөр байдлыг хадгалах

Баталгаажуулалтыг 3 жилийн хугацаанд дараах нөхцлүүд хангагдсан тохиолдолд хадгална. Үүнд:

(a) Магадлан хяналтын аудитыг төлөвлөсний дагуу явуулсан бөгөөд үйлчлүүлэгч нь баталгаажуулагдсан менежментийн тогтолцооны стандартын шаардлагыг хангаж байгаагаа нотлон харуулсан.

(b) Өмнөх магадлан хяналтын аудитын явцад илэрсэн үл тохирлыг хаалгасан.

(c) Дотоод аудит болон менежментийн дүн шинжилгээг хуваарийн дагуу үр дүнтэй явуулсан бөгөөд ямар нэгэн асуудал гараагүй болно.

(d) Үйлчлүүлэгч нь хэрэглэгчийн гомдлын зохих бүртгэлийг хөтөлж, барагдуулсан арга хэмжээг авсан талаарх бүртгэлийг ДС ББ-ын аудитуудад шалгуулсан.

(e) ДС ББ-д төлөх ёстой бүх төлбөрийг төлсөн байна.

5.5 Баталгаажуулалтыг түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон хамрах хүрээг багасгах

5.5.1. Баталгаажуулалтыг түдгэлзүүлэх

ДС ББ нь дараах тохиолдолд баталгаажуулалтыг түдгэлзүүлнэ:

(a) Үйлчлүүлэгчийн баталгаажуулагдсан менежментийн тогтолцоо нь баталгаажуулагдсан менежментийн тогтолцооны стандартын шаардлагыг үргэлжлүүлэн хангаагүй.

(b) Үйлчлүүлэгч нь шаардлагатай магадлан хяналтын болон давтан баталгаажуулалтын аудит хийхийг зөвшөөрөөгүй.

(c) ДС ББ-ын баталгаажуулалтын тэмдэг болон гэрчилгээг санаатайгаар буруу ашигласан.

(d) Үйлчлүүлэгч нь аливаа аудитын үед ирлэрсэн

- Том үл тохирлын залруулах арга хэмжээг үр дүнтэй авч 90 хоногийн дотор хаалгаагүй.
- Жижиг үл тохирлыг залруулж, 30 хоногт хаалгаагүй.

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ДҮРЭМ	DC R-02
	Батлагдсан огноо: 2025-12-25	Хувилбар № 01

Баталгаажуулалтыг дээд тал нь зургаан сарын хугацаатай түдгэлзүүлэх бөгөөд түдгэлзүүлсэн байдлыг ДС ББ-ын сайтад үйлчлүүлэгчдийн бүртгэл дээр олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

Энэ хугацаанд үйлчлүүлэгч нь ДС ББ-ын тэмдэг, гэрчилгээг эш татан ашиглахыг зогсооно.

5.5.2 Баталгаажуулалтыг цуцлах

ДС ББ нь дараах нөхцөлд баталгаажуулалтыг цуцлана. Үүнд:

- (a) Үйлчлүүлэгч зургаан сарын дотор түдгэлзүүлсэн асуудалд хариу арга хэмжээ аваагүй.
- (b) Хуулийн гомдол маргаан үүссэн, үйлчлүүлэгч хууль бус эсвэл зохисгүй үйл ажиллагаанд оролцсон гэх мэт бусад ноцтой шалтгаанууд.
- (c) Үйлчлүүлэгч нь өөрийн хүсэлтээр баталгаажуулалтын гэрээг цуцлах хүсэлт гаргасан.

Баталгаажуулалт нь хүчингүй болсон үйлчлүүлэгч нь ДС ББ-д баталгаажуулалтын гэрчилгээг буцаан өгөх үүрэгтэй.

5.5.3 Баталгаажуулалтын хүрээг багасгах

Үйлчлүүлэгч нь баталгаажуулалтын хамрах хүрээний тодорхой хэсгүүдэд тавигдах шаардлагыг удаа дараа, ноцтойгоор хангаагүй тохиолдолд ДС ББ нь тухайн шаардлага хангаагүй хэсгүүдийг хамрах хүрээнээс хасах байдлаар баталгаажуулалтын хүрээг багасгах шийдвэр гаргана.

5.6 Баталгаажуулалтын тэмдэг/лого ашиглах

Үйлчлүүлэгч нь баталгаажуулалтын гэрчилгээ олгогдох үед ДС ББ-ын өгсөн зааврын дагуу баталгаажуулалтын тэмдгийг сурталчилгааны материалд ашиглахдаа дараах нөхцлүүдийг хангана:

- (a) Интернэт, товхимол, сурталчилгаа болон бусад баримт бичигт баталгаажуулалтын статустай холбоотой эшлэл хийхдээ ДС ББ-ийн шаардлагыг мөрдөнө;
- (b) Баталгаажуулалтын тэмдэг болон гэрчилгээний талаар ташаа, төөрөгдүүлсэн мэдэгдэл хийхгүй;
- (c) Баталгаажуулалтын гэрчилгээ болон түүний хамрах хүрээг төөрөгдүүлсэн байдлаар ашиглахгүй;
- (d) Баталгаажуулалтыг түр түдгэлзсэн эсхүл цуцлагдсан тохиолдолд ДС ББ-ийн зааврын дагуу баталгаажуулалтад хамаарал бүхий бүх сурталчилгааны материалыг ашиглахаа нэн даруй зогсооно;
- (e) Баталгаажуулалтын хамрах хүрээ багассан тохиолдолд бүх сурталчилгааны материалыг зохих ёсоор шинэчилнэ;
- (f) Баталгаажуулалтын мэдээллийг бүтээгдэхүүн эсхүл үйлчилгээ баталгаажсан мэт ойлголт төрүүлэх байдлаар ашиглахгүй. Баталгаажуулалтын тэмдэг болон логог бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний сав баглаа боодол дээр ашиглахыг хориглоно;
- (g) Баталгаажуулалт нь хамрах хүрээнээс гадуурх үйл ажиллагаанд хамаарна гэсэн ойлголт төрүүлэхгүй;

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ДҮРЭМ	DC R-02
	Батлагдсан огноо: 2025-12-25	Хувилбар № 01

- (h) Баталгаажуулалтыг ДС ББ-ын баталгаажуулалтын тогтолцооны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх, олон нийтийн итгэлийг алдагдуулах байдлаар ашиглахгүй;
- (i) Баталгаажуулалтын логог нэрийн хуудас дээр ашиглахыг хориглоно.

5.7 Нийтэд нээлттэй мэдээлэл

ДС ББ нь дараах мэдээллийг өөрийн <https://dayan-certification.mn/> вэбсайт болон DC Inf - баримт бичгүүдээр дамжуулан нийтэд нээлттэй байлгана. Үүнд:

- аудитын үйл явц;
- баталгаажуулалт олгох, татгалзах, хадгалах, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, цуцлах үйл явц;
- баталгаажуулалтын хамрах хүрээг өргөтгөх эсхүл багасгах үйл явц;
- хэрэгжүүлж буй менежментийн тогтолцооны төрлүүд болон баталгаажуулалтын схемүүд;
- ДС ББ-ын баталгаажуулалтын байгууллагын нэр, тэмдэг, лого ашиглах журам;
- мэдээлэл авах хүсэлт, гомдол, маргааныг хүлээн авах, судлан шийдвэрлэх үйл явц;
- Шударга, хараат бус байдлын бодлого
- **шударга байдлыг хадгалах бодлого.**

Дээр дурдсанаас бусад бүх мэдээллийг нууцад тооцно.

5.8 Хүсэлт гаргагч/баталгаажуулагдсан байгууллагын үүрэг

Баталгаажуулагдсан байгууллага нь баталгаажуулалт олгогдсон хамрах хүрээнд ДС ББ-аас тогтоосон баталгаажуулалтын бүх шаардлагыг тасралтгүй хангах, мөн баталгаажуулалтын шаардлагад орсон өөрчлөлтийг мэдэгдсэн даруйд хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

- (a) Шаардлагатай тохиолдолд баталгаажуулалтын шаардлагыг хангах үйл ажиллагаандаа ДС ББ-тэй бүрэн хамтран ажиллана. Энэ нь баталгаажуулалтад хамрагдсан бүх байршилд хамаарна;
- (b) Баталгаажуулагдсан байгууллага нь олон салбартай тохиолдолд баталгаажуулалтын хамрах хүрээнд багтсан бүх салбарыг хамарсан хууль ёсны хүчин төгөлдөр гэрээг ДС ББ-тай байгуулна.
- (в) Өргөдөл гаргагч баталгаажуулалтын гэрчилгээ олгох, /аталгаажуулагдсан байгууллага нь гэрчилгээгээ хадгалахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг болон бүртгэлд ДС ББ-д хандах эрхийг олгоно.
- (г) Хүсэлт гаргагч/Баталгаажуулагдсан байгууллага нь /ДС ББ нь гэрчлэх аудитад хамрагдах зэрэг/ шаардлагатай тохиолдолд итгэмжлэлийн байгууллагын ажилтнуудад нэвтрэх

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ДҮРЭМ	DC R-02
	Батлагдсан огноо: 2025-12-25	Хувилбар № 01

боломжийг олгох бөгөөд ДС ББ-ийн хүсэлтээр мэдээлэл, баримт бичиг, бүртгэлд хандах эрхийг хангана.

(д) Баталгаажуулагдсан үйлчлүүлэгч нь зөвхөн баталгаажуулалтыг олгосон хамрах хүрээнд баталгаажуулалтын гэрчилгээгээ ашиглана.

(е) Баталгаажуулагдсан байгууллага нь баталгаажуулалтын гэрчилгээгээ ДС ББ-ийн нэр хүндийг гутаах байдлаар ашиглахгүй.

(ж) Хүсэлт гаргагч / баталгаажуулагдсан байгууллага нь ДС ББ-ийн тогтоосон төлбөрийг төлнө.

(з) Баталгаажуулагдсан үйлчлүүлэгч нь эрх бүхий зохицуулах байгууллагын оролцоог шаардсан зөрчил гаргасан, эсвэл тогтоосон дүрэм журам зөрчсөн тухайгаа ДС ББ-д нэн даруй мэдэгдэх.

(и) Хүсэлт гаргагч / баталгаажуулагдсан байгууллага нь өөрийн статус эсвэл үйл ажиллагаатай холбоотой холбоотой аливаа чухал өөрчлөлтийг нэн даруй ДС ББ-д мэдэгдэх үүрэгтэй. Үүнд:

(а) Хууль эрх зүйн статус эсвэл өмчлөл,

(б) Байгууллага ба менежмент (жишээ нь, удирдлага, шийдвэр гаргагч болон техникийн ажилтнуудын өөрчлөлт)

(с) Холбоо барих хаяг, байршил

(д) Баталгаажуулалтын хамрах хүрээ

(е) Менежментийн тогтолцооны болон үйл явцын томоохон өөрчлөлтүүд.

v) Баталгаажуулалтын шаардлагыг хангахад баталгаажуулагдсан байгууллагын чадварт нөлөөлж болзошгүй бусад асуудлууд

5.9 ДС Баталгаажуулалтын байгууллагын үүрэг

ДС ББ нь баталгаажуулагдсан байгууллагад олгосон гэрчилгээний байдлын талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгана. Мэдээллийг тогтмол шинэчилнэ. Мэдээлэлд дараах зүйлс орно:

- баталгаажуулагдсан үйлчлүүлэгчийн нэр, баталгаажуулагдсан стандарт, норматив баримт бичиг
- үйл ажиллагаа явуулдаг хаяг, байршил,
- олгогдсон баталгаажуулалтын гэрчилгээ, хамрах хүрээ;

ДС ББ нь баталгаажуулалтынн шаардлагадаа гарсан аливаа өөрчлөлтийн талаар заавал мэдэгдэнэ.

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ДҮРЭМ	DC R-02
	Батлагдсан огноо: 2025-12-25	Хувилбар № 01

6. Баталгаажуулалтын ерөнхий нөхцөл

(а) Цуцлах - ДС ББ нь Үйлчлүүлэгчид баталгаажуулалтыг цуцлах тухай 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэж, хүссэн үедээ цуцлах эрхтэй. Үйлчлүүлэгчийн зүгээс цуцлахыг хүссэн тохиолдолд цуцлах өдрөөс өмнөх бүх төлбөрийг ДС ББ-д төлсөн байна. Ямар ч тохиолдолд цуцлах төлбөр нь гэрээний үнийн дүнгийн 15%-иас хэтрэхгүй байх ёстой.

(б) Нууцлал - ДС ББ нь үйлчлүүлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр үйлчлүүлэгч эсвэл хувь хүний талаарх аливаа мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй. Хэрэв ДС ББ нь хуулиар нууц мэдээллийг гуравдагч этгээдэд задруулах шаардлагатай бол үйлчлүүлэгч эсвэл холбогдох хувь хүнд өгсөн мэдээллийн талаар урьдчилан мэдэгдэх ёстой.

(в). Давагдашгүй хүчин зүйл - аль нэг талын гүйцэтгэлийг хойшлуулах эсвэл биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй. Давагдашгүй хүчин зүйлд өртсөн тал нь шалтгаан болон таамаглаж буй үргэлжлэх хугацааны талаар нөгөө талд бичгээр мэдэгдэх ёстой.

(г) Хууль ба маргаан - ДС ББ болон Үйлчлүүлэгчийн хоорондох гэрээтэй холбогдуулан үүссэн, талуудын хоорондын хэлэлцээрээр шийдвэрлэх боломжгүй аливаа маргааныг Арбитрын тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ. Арбитрын шийдвэрийг хоёр тал заавал биелүүлэх үүрэгтэй.

(д) Баталгаажуулалтын шийдвэрийн маргаан: Үйлчлүүлэгч дараахь асуудлаар ДС ББ-д маргаан гаргаж болно. Үүнд:

I. Үйлчлүүлэгчийн баталгаажуулалтын хүсэлтийг хүлээн аваагүй тохиолдолд

II. Баталгаажуулалтын гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, цуцлах эсвэл татгалзах

ДС ББ нь дээрх маргааныг “Гомдол маргаан шийдвэрлэх” журмын дагуу авч үзэж, маргааны талаар гарах шийдвэрийг аль ч шатанд хариуцна. ДС ББ нь үйлчлүүлэгчийн гаргасан гомдол болон маргааныг хүлээн авснаа мэдэгдэн, үйлчлүүлэгчид явцын тайлан, үр дүнг хүлээлгэн өгнө.

(f) Гомдол: ДС ББ нь үйлчлүүлэгчээс хүлээн авсан гомдлыг шалгаж, ямар арга хэмжээ авах шаардлагатайг шийдэж, зохих цагт нь үйлчлүүлэгчид мэдэгдэнэ. Гомдол гаргагчийн нэрийг задруулахгүй.

(g) Баталгаажуулалтын төлбөрийг ДС ББ-ийн ирүүлсэн үнийн саналд дэлгэрэнгүй тусгана. Төлбөрийг холбогдох тарифын дагуу ногдуулна. ДС ББ нь Баталгаажуулалтын гэрчилгээний хугацаанд төлбөрийг өөрчилсөн бол өөрчлөлтийн талаар үйлчлүүлэгчдэд мэдэгдэнэ.

Хэрэв үйлчлүүлэгчид ямар нэгэн тусгай аудит хийсэн бол ДС ББ нь аудитын төлбөр болон бусад захиргааны зардлыг нөхөх зорилгоор энэ аудитын нэмэлт төлбөр авах бөгөөд үүнийг нэхэмжлэсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор төлөх ёстой.

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ДҮРЭМ	DC R-02
	Батлагдсан огноо: 2025-12-25	Хувилбар № 01

(h) Үйлчлүүлэгчийн байранд нэвтрэх: Үйлчлүүлэгч нь ДС ББ-ийн хүсэлтээр ДС ББ-ийн аудитууд болон эрх бүхий ажилтнуудад өөрсдийн байр, баримт бичиг болон бүртгэлд нэвтрэхийг зөвшөөрнө.

(I) Гэрээний хугацаа: Баталгаажуулалтын гэрээ нь үндэслэлтэй шалтгаанаар цуцлагдаагүй эсвэл аль нэг тал нөгөө талд зохих ёсоор мэдэгдсэний дараа цуцлагдаагүй тохиолдолд гэрчилгээний хугацаа дуусах хүртэл хүчин төгөлдөр байна.

(j) Хариуцлага: ДС ББ-ийн хариуцлага нь үйлчлүүлэгчийн менежментийн тогтолцооны баталгаажуулалтын гэрчилгээ олгохоор хязгаарлагдах бөгөөд үйлчлүүлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс үүдэлтэй хариуцлагыг ямар ч байдлаар хариуцахгүй.